

# МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

## ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

- 1** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
- 2** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
- 3** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр, дэг болон санамж
- 4** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлууд
  - 4.1. “МОСТ Финтек” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга
  - 4.2. “Хүлэгтхүннү аудит” ХХК-ийн “МОСТ Финтек ХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан”-ийн дүгнэлтийн танилцуулга
  - 4.3. “МОСТ Финтек” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн шийдвэр
  - 4.4. Хэлэлцэх асуудал N°01:  
“МОСТ Финтек” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - 4.5. Хэлэлцэх асуудал N°02  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг хэлэлцэж батлах;
  - 4.6. Хэлэлцэх асуудал N°03  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинээр гишүүдийг сонгох;
- 5** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл
- 6** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

## “МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“МОСТ Финтек” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 05/26 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

**Компанийн оноосон нэр:** “МОСТ ФИНТЕК” ХК

**Хурал болох газар:** Монгол Улс, Улаанбаатар хот, СБД 8-р хороо  
Сэнтрал Тауэр 13-р давхар 1313 тоот хурлын өрөөнд

**Хурал болох өдөр, цаг:** 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14 цагт

**Хурал болох хэлбэр:** Хосолсон (танхим болон цахимаар)

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр:**  
2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

Танилцуулах асуудал:

1. “МОСТ Финтек” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийн танилцуулга
2. “МОСТ Финтек” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэл

Хэлэлцэх асуудал:

1. “МОСТ Финтек” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг хэлэлцэж батлах;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинээр гишүүдийг сонгох;

**Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл;
2. Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан;
3. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
4. ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга;
5. Саналын хуудас;
6. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.

Хувьцаа эзэмшигч та 2026 оны 4 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани, хурал зохион байгуулах комисстой холбогдож, эсхүл компанийн цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд урьдчилсан санал хүлээн авах эцсийн хугацаа 2026 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 16:00 цаг байна.

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатарр дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал тауэр  
оффисын 13 давхар 1313 тоот

**Харилцах утас:** 7505-2727 **Цахим шуудан:** [info@most.mn](mailto:info@most.mn)

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

### МОСТ ФИНТЕК ХК

Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо Централ Тауэр 13-р давхар, 1313 тоот

Утас: 75052727

И-мэйл хаяг: info@most.mn



### МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 11-ны өдөр

Дугаар 05/26

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “МОСТ ФИНТЕК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.39.4 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, СБД 8-р хороо Централ Тауэр 13-р давхар 1313 тоотод хурлын өрөөнд танхимаар болон цахим хосолсон хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.
3. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Биржид, 2026 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн дотор Хувьцаа эзэмшигчид үйлчилж байгаа Үнэт цаасны компаниудад тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 16-ний өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн С.Оргил-г томилсугай.
6. Хурал зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд  
Ажлын хэсгийн дарга дарга: Н.Урнаа /Захиргаа, Санхүүгийн газрын Захирал/  
Гишүүд: Э.Цэлмэг /ГУЗ-ийн Нарийн бичгийн дарга/  
Э.Цэнд /Бизнесийн газрын захирал/  
Ж.Цолмонбаатар /Үйл ажиллагааны газрын захирал/  
Д.Баасансүрэн /Дата аналитист/

7. Хурлын тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:  
Ажлын хэсгийн дарга: Т.Отгонбаяр /Дата анализын газрын захирал/  
Гишүүд: Б.Баярцэцэг /Төслийн менежер/  
Д.Гэрэлтуяа /Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер/
8. Хурлын саналын хуудас /урьдчилан/-ыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал тауэр оффисын 13 давхар 1313 тоот хаягаар санал хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 17:00 цаг байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийг ажлын өдрүүдийн 10:00-17:00 цаг хүртэл компанийн байранд болон цахимаар хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах ажлын хэсэгт даалгасугай.
10. Энэхүү тогтоолын хавсралтаа дараах материалыг баталсугай.
  - 10.1 Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлын жагсаалт – Хавсралт №01
  - 10.2 Саналын хуудасны загвар – Хавсралт №02
  - 10.3 Хурлын нийтэд хүргэх зар – Хавсралт №03
  - 10.4 Танилцах материалын жагсаалт- Хавсралт №04
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлыг санхүүжүүлэхийг компанийн Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д зөвшөөрсүгэй.
12. Хурлын материалыг бэлэн болмогц брокер, дилерийн компаниудад хүргүүлэх, цахим хуудсаараа хувьцаа эзэмшигчдэд танилцуулах болон хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтыг саналын хуудас болон цахим хэлбэрээр явуулах, үүнд санал хураалтад оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр гүйцэтгэх, хуралд оролцогч бүрийн өгсөн саналыг хэвлэж, үнэн зөв болохыг баталгаажуулж, компанид хүлээлгэж өгөх үүрэг хүлээх зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР, ДЭГ БОЛОН САНАМЖ



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР, ДЭГ БОЛОН САНАМЖ


Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
14:00-14:10	Тооллогын комисс хурлын ирц бүртгэх, ирцийг мэдээллэх	Тооллогын комисс
14:10-14:15	Хурлын дарга хурлыг нээнэ.	Хурлын дарга С.Оргил
14:15-14:20	Хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулна.	ТУЗ-ийн НБД Э.Цэлмэг
14:20-15:00	Хэлэлцэх асуудлыг жагсаалтын дагуу танилцуулах: 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;	Гүйцэтгэх захирал С.Оргил Хүлэгтхүннү аудит ХХК-ийн аудитор
	2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийн үндэслэл танилцуулах;	Гүйцэтгэх захирал С.Оргил
	3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах;	ТУЗ-ийн НБД Э.Цэлмэг
	4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинээр гишүүдийг сонгох тухай	
15:00-15:10	Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	Гүйцэтгэх захирал С.Оргил
15:10-15:20	Санал хураалтыг эцэслэж, санал тоолох	Тооллогын комисс
15:20-15:30	Тооллогын комисс санал хураалтын дүнг хэлэлцсэн асуудал бүрээр танилцуулах	Тооллогын комисс
15:30-15:35	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах	ТУЗ-ийн НБД Э.Цэлмэг
15:36-15:40	Хурал хаах	Хурлын дарга С.Оргил

*Жич: Хурал хөтлөх явцад шаардлагатай тохиололд хурлын хугацаанд өөрчлөлт орж болно.*


# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛУУД

# “МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА


Гүйлгээний тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл



Гүйлгээний тоо, өсөлт, он оноор



Гүйлгээний төрөл, Орлогын эзлэх хувь




Хэрэглэгчийн тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл



Хэрэглэгчийн тоо, өсөлт, он оноор





Байгууллагын төрөл, Орлогын эзлэх хувь




## DigiPay

- DiGi Pay апп дээр МОСТ Паркинг нэвтэрсэн.
- Билл төлбөрийг хөгжүүлж эхэлсэн.



## Банк Төлөвлөгөө, Гүйцэтгэл

Гүйлгээний тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл



Хэрэглэгчийн тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл



## ББСБ

### ОНЛАЙН ЗЭЭЛ

- 10+ Зээл шинээр нэвтрүүлэв



- Хамтын ажиллагааны процесс тохирч Поларис апп-ууд МОСТ-н шийдлийг ашиглах болов.
- 2025 онд 6-н Поларис апп нэвтрэхээр тестийн шатанд хамтран ажиллаж байна.


### WHITELABEL

- УБ Кредит - UPay
- Жи Эс Би Капитал - SG Pay
- Их Ирээдүй Капитал - Easy Loan
- Вишнфанд - VisionFund апп-ууд үйл ажиллагаа нь идэвхжиж зээл гаргаж эхэлсэн




### Hipay

- QR харилцан холболт хийв.
- Билл төлбөрийн холболт сэргээж сайжруулав.



### Tarapay

- Зээл
- Цэнэглэлт
- Хэрэглэгч танин баталгаажуулах




### Төлөвлөгөө, Гүйцэтгэл

Гүйлгээний тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл



Хэрэглэгчийн тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл



### Зээл, Кредит Скор



- Жи Эс Би Капитал-н зээлийг Мост Мони апп-д хамтран нэвтрүүлж, сард 4000+ зээл гарч байна.



- LOS буюу шинэ зээлийн систем нэвтрүүлэхээр ажиллаж байна.
- Автомашны үнэлгээний боломж нэвтэрсэн.
- ScinScore, Buren Score-уудтай хамтын ажиллагаа эхлүүлсэн.
- MOST Score - AI модел сайжруулсан.

Гүйлгээний тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл



## Үнэт цаасны компани

### Хамтын Ажиллагаа




- Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд ГрэйтСити Монгол нь каспо апп шинээр элсүүлж, Каспо апп-ууд МОСТ-н шийдлийг ашиглах болов.



### Каспо апп

- ГрэйпСити Монгол-той хамтран каспо апп-ууд амжилттай нэвтрүүлэв.




### Каспо суурь систем

- Гадаад арилжаа
- Байгууллагын бүртгэл зэрэг шинэ боломж нэвтрүүлэв

### Төлөвлөгөө, Гүйцэтгэл

Гүйлгээний орлого, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл /Төгрөгөөр/



## Биллэр

### Элсүүлэлт

- Нийт 829 Биллэр МОСТ-д бүртгэлтэй байна
- 2025 онд Шинээр 94



МОСТ-той гэрээтэй биллэр



#### Цахилгаан түгээх

- Шинээр 2



#### МОСТ Паркинг

- Шинээр 35



#### Бусад

- Хялбар Төлбөрийн биллэр шинээр 33
- Масс мэдэгдлийн үйлчилгээ зарсан 6



#### ОСНАА

- Шинээр 12



#### СӨХ

- Шинээр 12




#### Холболт

- БИД
- Турбо
- Сэнд МН

### Онцлох ажлууд



#### Тээврийн хэрэгсэл цэс шинэчлэв



Тээврийн хэрэгсэл цэс шинээр нэвтрүүлж буй апп ууд



HiPay




SocialPay




Tino

## Биллэр, Төлөвлөгөө, Гүйцэтгэл

Гүйлгээний тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл




#### Онцлох төслүүд



- Short\_URL-р нэхэмжлэх илгээх боломж нэвтрүүлэв.
- Хэрэглэгчээс шимтгэл, Хураамж авах боломж
- Хэтэвч дээрх багц гүйлгээний боломж

Гүйлгээний тоо, өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэл



## Мерчант



#### Мерчант төв - Шинээр 5



#### Мерчант - Шинээр 336

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Мост Финтек ХК нь 2025 оны 01 сарын 02-ны өдрийн байдлаар нэгж хувьцааны ханш 49 төгрөг байсан бол 2025 оны 12 сарын 31-ний өдөр 48.99 төгрөгт хүрч 0.02% буурсан үзүүлэлттэй байна.



2025 оны 4,10 саруудад нэгж хувьцааны үнэ уналттай байж 30 төгрөгт хүрч байсан бол 2025 оны 12 сард өсөлттэй байж нэгж хувьцааны 48.99 төгрөгт хүрсэн байна. 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 23 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зах зээлийн үнэлгээ	23,807,655,603 төгрөг
Нийт гаргасан хувьцааны тоо	485,969,700 ширхэг
Хаалтын ханш	48.99 төгрөг


### Хувьцааны арилжаа

2025 онд нийт 614 удаагийн, 719 сая төгрөгийн үнийн дүн бүхий 18.8 сая ширхэг хувьцаа арилжаалагдсан байна.


Нийт арилжааны дүн:	719,139,551 төгрөг
Өдрийн дундаж арилжаа:	1,173,147 төгрөг
Нийт арилжааны ширхэг:	18,187,655 ширхэг
Өдрийн дундаж арилжааны ширхэг:	29,669 ширхэг
Дундаж ханш:	38.01 төгрөг

Санхүүгийн гол үзүүлэлт /сая төгрөгөөр/


нийт хөрөнгө




нийт борлуулалт



өөрийн хөрөнгө



цэвэр ашиг



	2023 он	2024 он	2025 он
нийт хөрөнгийн өгөөж	1.02%	5.34%	5.61%
өөрийн хөрөнгийн өгөөж	1.07%	5.52%	5.77%

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (төгрөгөөр)				
	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31	Өөрчлөлт төгрөгөөр	Өөрчлөлт хувиар
<b>Хөрөнгө</b>				
<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	774,338,031	682,285,678	(92,052,352)	-11.9%
Дансны авлага болон бусад авлага	3,901,219,552	4,381,900,067	480,680,515	12.3%
Бараа материал	878,458	1,329,335	450,877	51.3%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	430,885,755	550,967,310	120,081,555	27.9%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,900,000,000	1,900,000,000	-	0.0%
	<b>7,007,321,795</b>	<b>7,516,482,390</b>	<b>509,160,596</b>	<b>7.3%</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			-	
Үндсэн хөрөнгө	755,258,212	603,049,717	(152,208,495)	-20.2%
Биет бус хөрөнгө	4,934,918,147	5,008,295,483	73,377,336	1.5%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,828,094,852	2,468,094,852	640,000,000	35.0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,745,139,043	3,607,458,782	862,319,739	31.4%
	<b>10,263,410,254</b>	<b>11,686,898,834</b>	<b>1,423,488,580</b>	<b>13.9%</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>17,270,732,049</b>	<b>19,203,381,225</b>	<b>1,932,649,176</b>	<b>11.2%</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>				
<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
Дансны болон бусад өглөг	454,106,543	396,237,997	(57,868,547)	-12.7%
Татвар, НДШ-ийн өглөг	85,680,129	52,055,190	(33,624,939)	-39.2%
Хойшлогдсон татварын өр	17,157,119	111,382,368	94,225,249	6.5x
	<b>556,943,792</b>	<b>559,675,555</b>	<b>2,731,763</b>	<b>0.5%</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>556,943,792</b>	<b>559,675,555</b>	<b>2,731,763</b>	<b>0.5%</b>
<b>Эздийн өмч</b>			-	
Хувь нийлүүлсэн хөрөнгө	4,859,697,000	4,859,697,000	-	0.0%
Халаасны хувьцаа	(272,160,007)	(272,160,007)	-	0.0%
Нэмж төлөгдсөн капитал	6,795,689,845	6,795,689,845	-	0.0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,299,884,178	4,186,049,897	886,165,719	26.9%
Эздийн өмчийн бусад хэсэг	154,414,071	-	(154,414,071)	-100.0%
Хуримтлагдсан ашиг алдагдал	1,876,263,171	3,074,428,936	1,198,165,765	63.9%
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>16,713,788,257</b>	<b>18,643,705,670</b>	<b>1,929,917,412</b>	<b>11.5%</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>17,270,732,049</b>	<b>19,203,381,225</b>	<b>1,932,649,176</b>	<b>11.2%</b>

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (төгрөгөөр)				
	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31	Өөрчлөлт төгрөгөөр	Өөрчлөлт хувиар
Борлуулалтын орлого (цэвэр)	2,386,651,006	2,814,983,269	428,332,263	17.9%
Борлуулсан барааны өртөг	85,755,786	101,150,985	15,395,199	18.0%
Нийт ашиг (алдагдал)	2,300,895,220	2,713,832,284	412,937,064	17.9%
Хүүний орлого	696,117,235	693,732,494	(2,384,740)	-0.3%
Бусад орлого	-	-	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	562,061,592	639,326,298	77,264,706	13.7%
Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал	1,416,914,689	1,579,408,225	162,493,536	11.5%
Бусад олз (гарз)	1,920,114	3,046,981	1,126,867	58.7%
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,019,956,288</b>	<b>1,191,877,235</b>	<b>171,920,947</b>	<b>16.9%</b>
Орлогын татварын зардал	97,132,105	115,315,913	18,183,807	18.7%
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>922,824,183</b>	<b>1,076,561,322</b>	<b>153,737,140</b>	<b>16.7%</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>922,824,183</b>	<b>1,076,561,322</b>	<b>153,737,140</b>	<b>16.7%</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	1,002,441,311	1,002,441,311	100.0%
Орлогын нийт дүн	922,824,183	2,079,002,634	1,156,178,451	125.3%

# “ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ” ХХК-ИЙН “МОСТ ФИНТЕК ХК-ИЙН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН”-ИЙН ДҮГНЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### МОСТ Финтек ХК-ийн хувьцаа эзэмшигчид

#### Дүгнэлт

Бид МОСТ Финтек ХК (цаашид “компани” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын лон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “МНБЕЗ-н дүрэм” гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЕЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

#### Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга


материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:



И.Гүррагчаа  
Гүйцэтгэх захирал  
Хүлэгхүннү Аудит ХХК

2026 оны 03 дугаар сарын 09-ны өдөр  
Монгол Улс, Улаанбаатар хот

## “МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТАЛААР ШИЙДВЭРЛЭСЭН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

### МОСТ ФИНТЕК ХК

Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо Централ Тауэр 13-р давхар, 1313 тоот

Утас: 75052727

И-мэйл хаяг: info@most.mn



### МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар: 02/26

Улаанбаатар хот

#### *Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай*

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6 дахь хэсгүүд, “МОСТ ФИНТЕК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсэг болон компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор компанийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Хуульд заасны дагуу энэхүү шийдвэрийн үндэслэлийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
3. Энэхүү шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу хүргүүлэхийг Төлөөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
А.СҮХДОРЖ



**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №01:  
“МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ;**

**МОСТ ФИНТЕК ХК**

Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо Централ Тауэр 13-р давхар, 1313 тоот

Утас: 75052727

И-мэйл хаяг: info@most.mn



**МОСТ ФИНТЕК ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 11-ний өдөр

Дугаар 04/26

Улаанбаатар хот

*Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон  
аудитлагдсан санхүүгийн тайлангийн  
талаар дүгнэлт батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэхь заалт, “МОСТ ФИНТЕК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.39.6 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” хэмээн дүгнэсүгэй.
2. Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу хөндлөнгийн аудит хийсэн “Хүлэгт хүннү аудит” ХХК-ийн гаргасан хараат бус аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2-т заасан тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих эрх бүхий байгууллагад хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг компанийн Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д даалгасугай.
4. Компанийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /А.Сүхдорж/-д даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
А.СҮХДОРЖ**



# ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №02

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ;

### МОСТ ФИНТЕК ХК

Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо Централ Тауэр 13-р давхар, 1313 тоот

Утас: 75052727  
И-мэйл хаяг: info@most.mn



### МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 26-ны өдөр Дугаар 16/25 Улаанбаатар хот

#### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн 2026 оны төсвийг өргөн барих тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт,  
Компанийн засаглалын кодексийн 6 дугаар зүйлийг тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд өргөн барих ТУЗ-ийн 2026 оны төсвийг хавсралт ёсоор баталсугай.
2. Төсвийн саналыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



“МОСТ Финтек” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2025 оны 16/25 тоот тогтоолын Хавсралт №01

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ӨРГӨН БАРИХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТӨСӨВ



№	Зардлын төрөл	1 гишүүний цалингийн зардал (хурлын ирцээр)	1р улирал	2р улирал	3р улирал	4р улирал	Нийт зардал
<b>1 Суурь цалин:</b>							
	ТУЗ-н дарга	2,000,000	2,000,000	2,000,000	2,000,000	2,000,000	8,000,000
	ТУЗ-н гишүүн	1,500,000	12,000,000	12,000,000	12,000,000	12,000,000	48,000,000
2	Ээлжит бус/эчнээ санал хураалт	200,000	1,800,000	1,800,000	1,800,000	1,800,000	7,200,000
<b>3 Хорооны нэмэгдэл</b>							
	Хорооны дарга	300,000	1,800,000	1,800,000	900,000	900,000	5,400,000
	Хорооны гишүүн	200,000	2,400,000	2,400,000	1,200,000	1,200,000	7,200,000
4	НДШ-н зардал		2,725,000	2,500,000	2,012,500	2,237,500	9,475,000
5	Бусад з.байгуулалтын зардал		200,000	100,000	200,000	100,000	600,000
	Бусад болзошгүй зардал		1,000,000				1,000,000
<b>Нийт төсөв</b>			<b>25,725,000</b>	<b>22,600,000</b>	<b>18,312,500</b>	<b>20,237,500</b>	<b>86,875,000</b>

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №03

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН БҮРЭН ЭРХИЙГ ДУУСГАВАР БОЛГОЖ, ШИНЭЭР ГИШҮҮДИЙГ СОНГОХ;

“МОСТ Финтек” ХК-ийн дүрэмд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг 2 жил байхаар заасан. Тус бүрэн эрхийн хугацааны дагуу нийт ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрх 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дуусгавар болж байна.

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5.3-т “ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд дэвшүүлэх бүрэн эрхтэй” хэмээн заасны дагуу компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь 2026 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн хурлаараа дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлж байна.

Нэр дэвшүүлж буй ТУЗ-ийн ердийн гишүүнээр 6, хараат бус гишүүнээр 4 хүнийг нэр дэвшүүлж буйгаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хамгийн олон санал авсан ердийн 6, хараат бус 3 гишүүнийг сонгоно.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Эцэг/эх/-ийн нэр: Сангидаасүрэн  
 Өөрийн нэр: Сүхболд  
 Иргэншил: Монгол  
 Төрсөн он сар: 1989-02

### Боловсрол:

- МУИС, Бизнесийн удирдага, /4 жил/
- АНУ, Lindenwood University /4 жил/

### Ажлын туршлага:

- 2020 оноос одоог хүртэл Макс групп, Гүйцэтгэх захирал
- 2018 оноос одоог хүртэл “СҮҮ” ХК, ТУЗ-ийн гишүүн
- 2018 оноос одоог хүртэл “Бургер кинг”, “Макс хүнс”, Макс эксим Компаниудын Гүйцэтгэх хорооны захирал
- 2015-2017 – Бургер кинг, Стратеги хариуцсан захирал
- 2012-2014- - Hilton hotel, Аналист



Эцэг/эх/-ийн нэр: Ганбаатар  
 Өөрийн нэр: Тэлмэн  
 Иргэншил: Монгол  
 Төрсөн он сар: 1982-07

### Боловсрол:

- СЭЗИС, Бизнесийн удирдага, Бакалавр /4 жил/
- СЭЗИС, Бизнесийн удирдлагын магистр /2 жил/

### Ажлын туршлага:

- 2017 оноос одоог хүртэл Green gold finance credit union, Гүйцэтгэх захирал
- 2023 оноос одоог хүртэл Mongolian National Standard Cooperative, Гүйцэтгэх захирал
- 2021-2023 – National Federation of Pasture User Group NGO, Хамтын ажиллагаа, санхүү захиргааны ажилтан
- 2016-2021 – Green gold Animal health project, Хамтын ажиллагаа, захиргааны ажилтан
- 2013-2016 - Green gold project Санхүү захиргааны ажилтан, албаны дарга
- 2007-2013 – Coping with Desertification project, Санхүү захиргааны ажилтан, албаны дарга



Эцэг/эх/-ийн нэр: Болдбаатар  
 Өөрийн нэр: Баатармөнх  
 Иргэншил: Монгол  
 Төрсөн он сар: 1982.10

**Боловсрол:**

- АНУ, Баруун Мичиганы Их Сургууль, Нисэхийн шинжлэх ухаан, Бакалавр /2001-2005/
- АНУ, Баруун Мичиганы Их Сургууль, Санхүүд мэргэшсэн, Хөрөнгө оруулалтын сангийн удирдах сурагчаар сонгогдсон /Магистр /2007-2009/

**Ажлын туршлага:**

- 2022 оноос одоог хүртэл Ньюком групп, Гүйцэтгэх захирал
- 2017-2021 – Жэтстар ази/ Сингапур, Нисгэгч
- 2014-2017 - Ванилла эйр/ Япон, Нисгэгч
- 2010-2014 – Изинис монгол ХХК, Нисгэгч, Нислэгийн үй ажиллагаа эрхэлсэн дэд захирал
- 2005-2010 – АНУ, Багш нисгэгч



Эцэг/эх/-ийн нэр: Чоён  
 Өөрийн нэр: Хүрэлбаатар  
 Иргэншил: Монгол  
 Төрсөн он сар: 1982.03

**Боловсрол:**

- СЭЗИС, Бизнесийн удирдлага /2000-2004/
- СЭЗИС, Магистр, /2016-2018/

**Ажлын туршлага:**

- 2025-одоог хүртэл - Гурван бухат групп ХХК, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн захирал
- 2020-одоог хүртэл - Бат эксперт Консалтинг групп ХХК, Дэд захирал
- 2010-2020 - Улаанбаатар хотын банк, Эрсдэлийн шинжээ, Орлогч захирал / Уул уурхай, банк, олон улсын хөгжлийн төсөл, барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарт 15+ жилийн туршлагатай, санхүүгийн стратеги, эрсдэлийн удирдлага, төслийн санхүүжилт, эдийн засгийн болон санхүүгийн шинжилгээний чиглэлээр мэргэшсэн удирдах түвшний менежер.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



### Боловсрол:

- ЗХУ, Украин, Политехникийн дээд сургууль, Компьютерийн инженер /1970-1975/

### Ажлын туршлага:

- 2018 оноос одоог хүртэл – “МОСТ Финтек” ХК, “Грэйпсити монгол” ХХК, ТУЗ-ийн дарга
- 2008-2018 – “МОСТ Финтек” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2000-2007 – “Грэйпсити монгол” ХХК, Гүйцэтгэх захирал
- 1991-2000 – БСБ сервис ХХК, Гүйцэтгэх захирал
- 1988-1991 – Улсын банкны тооцоолох төв, Дарга
- 1975-1988 – Улсын төлөвлөгөөний комисс тооцоолох төв, Ерөнхий инженер

Эцэг/эх/-ийн нэр: Авир  
 Өөрийн нэр: Сүхдорж  
 Иргэншил: Монгол  
 Төрсөн он сар: 1951-02



### Боловсрол:

- Унгар, Budapest University of Economic Sciences, Эдийн засагч /1993-1997/
- АНУ, Stonier/АВА, Мэргэжил дээшлүүлэх сургалт /2002/
- АНУ, Бүтээлч манлайллын төв, Манлайллын хөтөлбөр, /2005/
- АНУ, Харвард кенниди их сургууль, 21-р зууны Дэлхийн манлайлал ба олон улсын нийтийн бодлого /2010/

### Ажлын туршлага:

- 2013 оноос одоог хүртэл Ард даатгал ХК, Ард кредит БСБ, ТУЗ-ийн дарга
- 2014 оноос одоог хүртэл Ард санхүүгийн нэгдэл, Гүйцэтгэх захирал
- 2012-2014 – “И Ай Ти” ХХК, ТУЗ-ийн дарга
- 2010-2012 – Монгол улсын Сангийн яамны Дэд сайд
- 2002-2009 – ХасБанк, Гүйцэтгэх захирал
- 1999-2001 – “Х.А.С” БСБ, Гүйцэтгэх захирал
- 1997-1998 – Монгол банк, Хянан шалгагч
- 1991-1992 – Монголын хөрөнгийн бирж, Хянан шалгагч, орчуулагч

Эцэг/эх/-ийн нэр: Чулуун  
 Өөрийн нэр: Ганхуяг  
 Иргэншил: Монгол  
 Төрсөн он сар: 1973-11



**Боловсрол:**

- АНУ, Колорадогийн их сургууль, Ерөнхий /1998-2000/
- Авсрали, AlphaBeta коллеж, Мэдээллийн технологийн удирдлага /2001-2002/
- Австрали, Сиднейн технологийн их сургууль, Программ хангамжийн инженер /2002-2006/

**Ажлын туршлага:**

- 2019 оноос одоог хүртэл “МОСТ Финтек” ХК, Гүйцэтгэх захирал
- 2012-2019 – “МОСТ Финтек” ХХК, Үйл ажиллагаа хариуцсан захирал
- 2009-2012 – “МОСТ Финтек” ХХК, Ерөнхий захирал
- 2014-2022 – “ПостКэйр” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2007-2009 – Гаалийн ерөнхий газар, Мэргэжилтэн
- 2006-2019 – МОСТ Өргөө ХХК, Гүйцэтгэх захирал

Эцэг/эх/-ийн нэр: Сүхдорж  
 Өөрийн нэр: Оргил  
 Иргэншил: Монгол  
 Төрсөн он сар: 1980-06



**Боловсрол:**

- Авсрали, Сидней хотын технологийн их сургуулийн Insearch институт, Программ хангамжийн инженер /2002-2004/
- Австрали, Сиднейн технологийн их сургууль, Программ хангамжийн инженер /2004-2006/

**Ажлын туршлага:**

- 2018 оноос одоог хүртэл “Грэйпсити монгол” ХК, Гүйцэтгэх захирал
- 2013-2018 – “Грэйпсити монгол” ХХК, Бизнесийн газрын захирал
- 2010-2011 – “Азийн хөгжлийн банкны дэвшилтэт хөдөлгөөнт банкны төсөл”, Хөдөлгөөнт банк, харилцаа холбооны эрх зүйн зөвлөх
- 2007-2013 “Грэйпсити монгол” ХХК, Төлбөрийн шийдлийн газрын дарга
- 2006-2007 – “Грэйпсити монгол” ХХК, Саппорт инженер

Эцэг/эх/-ийн нэр: Баасандорж  
 Өөрийн нэр: Мөнхцэцэг  
 Иргэншил: Монгол  
 Төрсөн он сар: 1980-09



**Боловсрол:**

- МУИС-ЭЗС, Эдийн засаг, бакалавр /2008-2012/
- МУИС-ХШУИС, Хэрэглээний математик, Магистр /2014-2016/

**Ажлын туршлага:**

- 2012 - 2018 онуудад Монголбанкны мөнгөний бодлогын газарт Макро эдийн засгийн загварчлал хариуцсан ахлах эдийн засагч
- 2018-2022 онуудад М банкны загварчлал хариуцсан өгөгдлийн шинжээч
- 2022-2024 онд Шинэ Сэргэлтийн Бодлогын Хурдасгуур Төв УТУГын Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн даргаар ажиллахын зэрэгцээ МУИС-д цагийн багшаар ажиллаж байв.
- 2024 оноос Ард санхүүгийн нэгдэл ХК, Дата судалгаа эрхэлсэн захирал
- 2025 оноос Ард кредит ББСБ ХК, Дижитал хөгжил эрхэлсэн захирал

Дэлхийн банкны зөвлөх, Сангийн яамны ахлах зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай.

Эцэг/эх/-ийн нэр: Чулуун  
Өөрийн нэр: Алтан-өлзий  
Иргэншил: Монгол  
Төрсөн он сар: 1990-01



**Боловсрол:**

- Raffles International Institute, бакалавр /2011-2014/
- МУИС- Магистр /2017-2018/

**Ажлын туршлага:**

- 2012 - 2013 Комит сервис ХХК, Гадаад харилцааны менежер
- 2013-2014 Наран групп ХХК, Гадаад харилцааны менежер
- 2014-2016 Таван богд групп ХХК, Гадаад харилцааны менежер
- 2018-2020 Оюуны ундраа групп ХХК, Бизнеси хөгжлийн газрын дарга
- 2021-одоог хүртэл МУИС, Бизнесийн сургуулийн багш
- 2022-одоог хүртэл Блюпринт Солиушн ХХК, Гүйцэтгэх захирал
- 2023-одоог хүртэл, Тоото Проптек ХХК, Гүйцэтгэх захирал
- 2024-одоог хүртэл Дижитал рэспо ХХК, Бизнес хариуцсан захирал

Технологид суурилсан бизнесийн стратеги, платформ болон SaaS бүтээгдэхүүн хөгжүүлэлт, байгууллагын процесс ба системийн дизайн дээр туршлагатай. Шинэ зах зээл нээх, бүтээгдэхүүн-зах зээлийн нийцэл (product-market fit) бий болгох, бизнесийг хурдтай масштабжуулах чиглэлд ажиллаж ирсэн.

Эцэг/эх/-ийн нэр: Энхбат  
Өөрийн нэр: Мөнхсаруул  
Иргэншил: Монгол  
Төрсөн он сар: 1990-01

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ

### “МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 04 сарын 22-ны өдөр

Дугаар: ХЭХ-01/26

Улаанбаатар хот

#### ***Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “МОСТ ФИНТЕК” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, “МОСТ ФИНТЕК” ХК /цаашид “Компани” гэх/-ийн 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/25 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “МОСТ ФИНТЕК” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 04/26 тоот тогтоолоор өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

С.ОРГИЛ

## “МОСТ ФИНТЕК ХК”-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 сарын 22-ны өдөр

Дугаар: ХЭХ-02/25

Улаанбаатар хот

### *Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “МОСТ ФИНТЕК” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, “МОСТ ФИНТЕК” ХК /цаашид “Компани” гэх/-ийн 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/25 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “МОСТ ФИНТЕК” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.ОРГИЛ

*“МОСТ Финтек” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн ХЭХ-02/25 тоот шийдвэрийн  
Хавсралт №01*

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	1 гишүүний цалингийн зардал (хурлын ирцээр)	1р улирал	2р улирал	3р улирал	4р улирал	Нийт зардал
<b>1</b>	<b>Суурь цалин:</b>						
	ТУЗ-н дарга	2,000,000	2,000,000	2,000,000	2,000,000	2,000,000	8,000,000
	ТУЗ-н гишүүн	1,500,000	12,000,000	12,000,000	12,000,000	12,000,000	48,000,000
<b>2</b>	<b>Ээлжит бус хурлын нэмэгдэл</b>	200,000	1,800,000	1,800,000	1,800,000	1,800,000	7,200,000
<b>3</b>	<b>Хорооны нэмэгдэл</b>						
	Хорооны дарга	300,000	1,800,000	1,800,000	900,000	900,000	5,400,000
	Хорооны гишүүн	200,000	2,400,000	2,400,000	1,200,000	1,200,000	7,200,000
<b>4</b>	<b>НДШ-н зардал</b>		2,725,000	2,500,000	2,012,500	2,237,500	9,475,000
<b>5</b>	<b>Бусад зохион.байгуулал тын зардал</b>		1,200,000	100,000	200,000	100,000	1,600,000
	<b>НИЙТ ТӨСӨВ</b>		<b><u>25,725,000</u></b>	<b><u>22,600,000</u></b>	<b><u>18,312,500</u></b>	<b><u>20,237,500</u></b>	<b><u>86,875,000</u></b>

*\*2027 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг  
дуустал 12 сарын нэгтгэсэн дүнгээр*

## “МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 сарын 22-ны өдөр

Дугаар: ХЭХ-03/25

Улаанбаатар хот

### *Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинээр сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 63 дугаар зүйлийн 63.6 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэхь хэсэг, 2025 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 02/25 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан доорх нэр дэвшигчдийг 2028 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 /хоёр/ жилийн хугацаатайгаар сонгосугай.
  - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
    - 1.1.1
    - 1.1.2
    - 1.1.3
    - 1.1.4
    - 1.1.5
    - 1.1.6
  - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
    - 1.2.1
    - 1.2.2
    - 1.2.3
2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан компанийн өмнөх Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонгогдсонтой холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаа сонгох, хороодыг шинэчлэн байгуулах, компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хууль болон Компаний дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд үр ашигтай бөгөөд зохистойгоор удирдах явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ТУЗ-ийн гишүүдийн талаар олон нийтэд мэдээллэх, гишүүдийн мэдээллийг эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Э.Цэлмэг/-д итгэмжилэн даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.ОРГИЛ

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ ӨГӨХ САНАЛЫН ХУУДАС

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ ӨГӨХ САНАЛЫН ХУУДАС

### “МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС №01

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: \_\_\_\_\_

Бүртгэсэн брокер, дилерийн компани: \_\_\_\_\_

Бүртгэсэн брокерийн овог, нэр: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Энэхүү саналын хуудсаар 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 14 цагт хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;			
2.	ТУЗ-ийн 2026 оны төсөв батлах;			

#### Саналын хуудас ашиглах заавар:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудас бөглөхдөө санал өгөх хэсэгт (√) тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани дээр 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 17 цагаас өмнө очиж хурлын материалтай танилцаж санал өгнө.
- Хэрэв өөр этгээдээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэлийг хуульд заасан журмаар олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн энэ хурлын хувьд хүчинтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулна.
- Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
- Санал авах хуудас хүчингүйд тооцсон шалтгааныг энд дурдана уу.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:

#### ХУВЬ ХҮН БОЛ:

Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр:

.....

Гарын үсэг:.....

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:

.....

Регистрийн дугаар:

.....

Гарын үсэг:.....

#### ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр:

.....

Регистрийн дугаар:.....

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:

.....

Гарын үсэг:.....

**“МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС №02**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: \_\_\_\_\_  
 Регистрийн дугаар: \_\_\_\_\_  
 Эзэмшиж буй хувьцааны төрөл: \_\_\_\_\_Энгийн\_\_\_\_\_  
 Бүртгэсэн брокер, дилерийн компани: \_\_\_\_\_  
 Бүртгэсэн брокерийн овог, нэр: \_\_\_\_\_  
 Санал өгөх эрхийн тоо: \_\_\_\_\_

Энэхүү саналын хуудсаар 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 14 цагт хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	ТУЗ-ийн нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
<b>Ердийн гишүүн</b>		
1.	Авир овогтой Сүхдорж	
2.	Чулуун овогтой Ганхуяг	
3.	Сүхдорж овогтой Оргил	
4.	Баасандорж овогтой Мөнхцэцэг	
5.	Энхбат овогтой Мөнхсаруул	
6.	Чулуун овогтой Алтан-өлзий	
<b>Хараат бус гишүүн</b>		
1.	Болдбаатар овогтой Баатармөнх	
2.	Сангидаасүрэн овогтой Сүхболд	
3.	Ганбаатар овогтой Тэлмэн	
4.	Чоён овогтой Хүрэлбаатар	

*(Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ-ийн 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй (100\*9гишүүн=900) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу)*

**Саналын хуудас ашиглах заавар:**

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудас бөглөхдөө санал өгөх хэсэгт (√) тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани дээр 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 17 цагаас өмнө очиж хурлын материалтай танилцаж санал өгнө.
3. Хэрэв өөр этгээдээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэлийг хуульд заасан журмаар олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн энэ хурлын хувьд хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулна.
5. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
6. Санал авах хуудас хүчингүйд тооцсон шалтгааныг энд дурдана уу.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:**

**ХУВЬ ХҮН БОЛ:**

Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр:  
 .....  
 Гарын үсэг:.....  
 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:  
 .....  
 Регистрийн дугаар:  
 .....  
 Гарын үсэг:.....

**ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:**

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр:  
 .....  
 Регистрийн дугаар:.....  
 Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:  
 .....  
 Гарын үсэг:.....

